



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** ДГА-2019/151/СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Сайншанд 2019 он	Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа Утас: 70522734      Цахим хаяг: ariunaa.ch@audit.gov.mn Аудитын менежер: Ц.Лүндэгмаа Утас: 70503020      Цахим хаяг: lundegmaa@audit.gov.mn Аудитор:              Б.Уранбилэг Утас: 70523020      Цахим хаяг: uranbileg.b@audit.gov.mn
---	--

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт

## АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ .....	
2	Аудитын тайлан.....	3
2.1	Оршил.....	3
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	8
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	8
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	8
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	9
2.11	Шилэн дансны мэдээлэл .....	10
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	10
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	11
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	13

## 1 Аудитын гэрчилгээ

  
**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**  
44-03 Дорноговь аймэг, Сайванд сум  
Орон нутгийн өмчийн ШБЗ-р  
Утас: (705) 2-27-34

**МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ  
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВИЙН  
ЗАХИРАЛ Б.АДИЛБИШ ТАНАА**

2019.02.25 № 1-6/197  
Танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар дагуу Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв нь 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

502000-

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг, хариуцлага**

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

## 2 АУДИТЫН ТАЙЛАН

### ОРШИЛ

Дорноговь аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал Б.Адилбиш-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### **Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019/02/14-нөөс 2019/02/15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019/02/19-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар-ын Б.Уранбилэг хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн МСҮТ 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар-т 2019/01/25-ны өдрийн 12 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

## **Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Дорноговь аймгийн МСҮТ нь “Мэргэжлийн боловсрол, сургалтын зорилго нь иргэний авьяас, сонирхол, хөдөлмөр эрхлэх хэрэгцээнд тулгуурлан боловсролын үндсэн зарчим, олон улсын нийтлэг жишиг, хандлагад нийцүүлэн мэргэжлийн ур чадвар, боловсрол эзэмшүүлэх, мэргэшлийг дээшлүүлэх, хөдөлмөрийн болон харилцааны соёл төлөвшүүлэхэд оршино” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Дорноговь аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн дүрэмд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, иргэний сонирхол, авьяас чадварыг харгалзан ажил олгогчийн шаардлагад нийцсэн мэргэжилтэй ажилтан бэлтгэх, хувь хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр техникийн болон мэргэжлийн боловсрол олгох, мэргэжлийн болон ур чадвар эзэмшүүлэх сургалтыг зохион байгуулна.

Дорноговь аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Дорноговь аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн ДГА-2019/151/СТА/ТШЗ

баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай

Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Дорноговь аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд Шаардлагагүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Дорноговь аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolous” програм хангамж ашигладаг байна.

Дорноговь аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөтэй гэж үзлээ.

Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Дорноговь аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 13 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 7 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр *Нийт зардал*-ын 1 хувиар сонгов.

*Нийт зардал*-г материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь нийт хөрөнгийн дүнгээс бага байгаатай холбоотой юм.

Дорноговь аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв 2018 оны *Нийт зардал* 12,796.78 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 12,796.78 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь 1 холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 11 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 3 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 8 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэнээс гадна 2 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Албан шаардлага өгсөн	2	16118.4	

**2.1.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал**

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

**2.8.1.1 Батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй холбоотой асуудал**

Тус байгууллага 2018 онд хичээл үйлдвэрлэлийн зардлаас холбогдох зөвшөөрөлгүйгээр тэмцээн уралдаан, шагнал, төлбөр хураамжийн зардалд нийт 7568.4 мянган төгрөгийг, цалин хөлсний зардлаас багш, ажиллагсадд түлээ түлшний хөнгөлөлтөд 8550.0 мянган төгрөгийг холбогдох байгууллагын зөвшөөрөлгүй зарцуулсан.

Энэ нь “Толилуулга ба тодруулга” батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн:** Зориулалт бусаар зарцуулсан дээрх зөрчилд алдааг дахин давтахгүй байх, холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллах тухай албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

**2.8.1.2 Зардлын данстай холбоотой асуудал**

2018 оны 12 дугаар сарын 10-ны өдөр “Сурагчдын бэлтгэлийн хувцас нийлүүлэх” гэрээг байгуулсан байна. Гэрээний дуусгах хугацаа 2019/02/28-ны өдөр байтал нийлүүлэх ажлын гүйцэтгэл тодорхойгүй, санхүүжилтийн 60 хувийг шилжүүлсэн байна.

**Шийдвэрлэсэн:** Дээрх гэрээнд заасан хугацаанд гэрээт ажлыг дуусгаж, хүлээж авах тухай албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

2018 оны 10 дугаар сард байгууллагын ахмадуудад хүндэтгэл үзүүлэхэд зарцуулсан 504.0 мянган төгрөгийг хичээл үйлдвэрлэлийн зардлаас зарцуулснаар бүртгэж, тайлагнасан байна.

**Шийдвэрлэсэн:** Дээрх алдааг хүлээн зөвшөөрч бүртгэлийн алдааг залруулав.

**2.8.1.3 Балансын зүйлтэй холбоотой**

2018 онд салбарын болон бусад байгууллагын цол, тэмдгээр шагнагдсан багш ажиллагсадд байгууллагын захирлын тушаалаар гарсан дагалдах мөнгөн шагнал болох 900.0 мянган төгрөгийг олгоогүй ба үүнийг санхүүгийн тайланд бүртгэж тусгаагүй байна.

**Шийдвэрлэсэн:** Дээрх алдааг хүлээн зөвшөөрч 900.0 төгрөгийг өглөгөөр тусгаж, залруулав.

Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дорноговь аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 5 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 1010238.4 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 967595.8 мянган төгрөг буюу 93 хувьтай байгаа нь шалтгаалжээ.

Багшийн орон тоо дутуугаас зардлын хэмнэлт үүсэж, төсөвт 69586.7 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Шилэн дансны мэдээлэл

Дорноговь аймгийн МСҮТ Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дорноговь аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын

дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг  
Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### 3 Аудит хийсэн санхүүгийн тайлан

#### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ҮЛДЭГДЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	229,329,709.13	179,609,092.08
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	3,484,750.00	2,475,250.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	3,484,750.00	2,475,250.00
3121	Төгрөг	3,484,750.00	2,475,250.00
31211	Төрийн сангийн харилцах	3,484,750.00	2,475,250.00
33	АВЛАГА	401,148.00	419,946.00
335	Бусад авлага	401,148.00	419,946.00
3351	Байгууллагаас авах авлага	248,633.00	183,211.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	152,515.00	236,735.00
34	УРЬДЧИЛГАА	23,510,163.00	1,320,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	23,510,163.00	1,320,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	201,933,648.13	175,393,896.08
354	Хангамжийн материал	201,933,648.13	175,393,896.08
35410	Бичиг хэргийн материал	1,999,910.00	1,660,820.00
35420	Аж ахуйн материал	166,901,913.75	163,668,678.34
35450	Барилгын засварын материал	30,535,650.00	5,372,070.00
35460	Хүнсний материал	1,376,974.38	2,767,855.74
35470	Бусад хангамжийн материал	1,119,200.00	1,924,472.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,002,698,180.99	3,756,682,894.12
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,002,698,180.99	3,756,682,894.12
392	Биет хөрөнгө	2,998,720,576.77	3,321,162,477.33
39201	Барилга, байгууламж	3,940,226,821.56	3,115,173,204.12
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,324,807,211.70)	(59,962,146.90)
39203	Авто тээврийн хэрэгсэл	60,200,000.00	60,200,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(56,400,396.70)	(58,662,301.42)
39205	Машин, тоног төхөөрөмж	1,188,928,259.34	1,188,928,259.34
39206	Хуримтлагдсан элэгдэл	(956,965,757.21)	(1,056,840,334.13)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	182,631,745.59	182,631,745.59
39208	Хуримтлагдсан элэгдэл	(113,999,542.54)	(129,508,107.70)
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,440,000.00	-
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,440,000.00)	-
39217	Номын фонд	78,906,658.43	79,202,158.43
393	Биет бус хөрөнгө	3,977,604.22	435,520,416.79
39301	Програм хангамж	16,830,000.00	16,830,000.00
39302	Хасагдуулга	(12,852,395.78)	(16,669,583.21)
39303	Бусад биет бус хөрөнгө	-	435,360,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	3,232,027,890.12	3,936,291,986.20
4	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	142,679.85	1,220,454.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	142,679.85	1,220,454.00
413	Өглөг	142,679.85	1,220,454.00
41310	Ажиллагчидтай холбогдсон өглөг	-	231,095.00
4136	Бусад өглөг	142,679.85	989,359.00
41361	Байгууллагад төлөх өглөг	15,663.85	43,000.00
41362	Хувь хүмүст төлөх өглөг	127,016.00	946,359.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	3,231,885,210.27	3,935,071,532.20
51	Засгийн газрын хувь оролцоо	3,231,885,210.27	3,935,071,532.20
511	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	1,495,096,307.08	1,930,456,307.08
51101	Өмч: -Төрийн өмч	1,495,096,307.08	1,930,456,307.08
512	Хуримтлагдсан үр дүн	860,248,502.87	998,238,566.15
51210	Өмнөх үеийн үр дүн	860,248,502.87	1,048,225,689.98
51220	Тайлант үеийн үр дүн	-	(49,987,123.83)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	876,540,400.32	1,006,376,658.98
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	3,232,027,890.12	3,936,291,986.20

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ГҮЙЦЭТГЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,005,218,187.43	1,230,590,956.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	13,871,387.43	191,846,670.00
120	Нийтлэг татварын бус орлого	11,405,897.43	191,846,670.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	11,405,897.43	191,846,670.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,265,337.00	5,360,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,000,000.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,140,560.43	186,486,670.00
121	Хөрөнгийн орлого	2,465,490.00	-
121001	Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	2,465,490.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	991,346,800.00	1,038,744,286.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	991,346,800.00	1,031,738,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	991,346,800.00	1,031,738,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	6,600,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	6,600,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс	-	405,886.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	405,886.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	1,197,645,590.76	1,280,578,079.83
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,197,645,590.76	1,280,578,079.83
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,033,116,247.56	1,146,014,706.88
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	503,694,263.00	539,841,340.00
210101	Цалин	392,744,976.00	373,788,721.00
210102	Нэмэгдэл цалин	76,994,487.00	123,775,019.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	33,954,800.00	42,277,600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	55,006,747.00	65,012,770.00
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	55,006,747.00	65,012,770.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	156,473,546.00	164,047,730.00
210301	Гэрэл цахилгааны зардал	10,126,164.00	12,352,060.00
210302	Түлш, халаалтын зардал	134,369,158.00	134,369,158.00
210303	Цэвэр, бохир усны зардал	11,978,224.00	17,326,512.00
2104	Хангамж, бараа материалын зардал	26,535,825.28	22,012,888.61
210401	Бичиг хэргийн материал	3,459,003.80	3,384,997.00
210402	Тээвэр, шатахууны зардал	5,061,770.41	2,996,604.00
210403	Шуудан холбоо интернетийн төлбөр	4,191,340.00	3,850,452.20
210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх	740,150.00	670,000.00
210408	Бараа материал актасны зардал	13,083,561.07	11,110,835.41
2105	Нормативт зардал	32,775,008.22	35,816,308.64
210501	Эм	87,000.00	256,150.00
210502	Хоол	29,810,931.22	31,162,810.64
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,877,077.00	4,397,348.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,420,630.00	40,217,740.00
210604	Урсгал засвар	11,420,630.00	40,217,740.00
2107	Томиллот, зочны зардал	4,361,450.00	3,988,500.00
210702	Дотоод томиллотын зардал	4,361,450.00	3,988,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	4,315,750.00	4,383,551.00
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	1,440,000.00	1,440,000.00
210803	Даатгалын үйлчилгээний төлбөр	2,626,882.00	2,694,683.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	160,868.00	160,868.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	88,000.00	88,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	238,533,028.06	270,693,878.63
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	50,000.00	-
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	39,717,493.75	84,828,746.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	198,765,534.31	185,865,132.63
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	164,529,343.20	134,563,372.95
2132	Бусад урсгал шилжүүлэг	51,853,992.00	64,976,654.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	2,492,976.00	22,860,768.00
213208	Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	31,353,232.00	40,206,386.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	18,007,784.00	1,909,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	112,675,351.20	69,586,718.95
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	112,675,351.20	69,586,718.95
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	(192,427,403.33)	(49,987,123.83)
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)	50,000.00	-
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	50,000.00	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	112,000.00	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	112,000.00	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)	(62,000.00)	-
5	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	(192,489,403.33)	(49,987,123.83)

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ГҮЙЦЭТГЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,013,549,019.00	1,049,110,685.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	13,313,775.00	5,444,078.00
120	Нийтлэг татварын бус орлого	13,313,775.00	5,444,078.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	13,313,775.00	5,444,078.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,495,337.00	5,360,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,818,438.00	84,078.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,000,235,244.00	1,043,666,607.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	991,346,800.00	1,031,738,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	991,346,800.00	1,031,738,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	6,600,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	6,600,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	8,888,444.00	5,328,207.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	8,888,444.00	5,328,207.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	1,010,624,269.00	1,049,824,685.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,010,624,269.00	1,049,824,685.00
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	834,963,015.80	910,833,105.05
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	493,449,666.00	539,719,381.00
210101	Үндсэн цалин	382,500,379.00	373,666,762.00
210102	Нэмэгдэл	76,994,487.00	123,775,019.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	33,954,800.00	42,277,600.00
2102	Ажил олгогчоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	56,577,968.00	64,475,611.00
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	56,577,968.00	64,475,611.00
2103	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	144,672,044.00	140,537,567.00
210301	Гэрэл цахилгааны зардал	9,856,256.00	12,352,060.00
210302	Түлш, халаалтын зардал	122,837,564.00	112,091,331.00
210303	Цэвэр, бохир усны зардал	11,978,224.00	16,094,176.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,878,969.80	14,347,691.20
210401	Бичиг хэрэг	4,773,469.80	3,154,445.00
210402	Тээвэр, шатахуун	3,871,060.00	4,203,694.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,393,490.00	4,073,552.20
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	802,950.00	670,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	38,000.00	2,246,000.00
2105	Нормативт зардал	33,854,757.00	36,294,525.85
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	87,000.00	304,650.00
210502	Хоол, хүнс	30,201,015.00	32,644,255.85
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,566,742.00	3,345,620.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,467,930.00	23,905,820.00
210601	Багаж техник хэрэгсэл	515,800.00	1,717,900.00
210604	Урсгал засвар	7,952,130.00	22,187,920.00
2107	Томилолт, зочны зардал	4,361,450.00	3,988,500.00
210702	Дотоод албан томилолт	4,361,450.00	3,988,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,464,250.00	4,383,551.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,440,000.00	1,440,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,626,882.00	2,694,683.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	160,868.00	160,868.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	88,000.00
210808	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	148,500.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	75,235,981.00	83,180,458.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх	75,235,981.00	83,180,458.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	175,661,253.20	138,991,579.95
2132	Бусад урсгал шилжүүлэг	62,985,902.00	69,404,861.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмж	8,888,444.00	5,328,207.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	695,250.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	2,492,976.00	22,860,768.00
213208	Хөдөө орон нутагт тогвортой ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	31,353,232.00	40,206,386.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	19,556,000.00	1,009,500.00

**Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	112,675,351.20	69,586,718.95
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	112,675,351.20	69,586,718.95
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	2,924,750.00	(714,000.00)
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	590,000.00	295,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	590,000.00	295,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	590,000.00	295,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	590,000.00	295,500.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(590,000.00)	(295,500.00)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	2,334,750.00	(1,009,500.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,150,000.00	3,484,750.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,484,750.00	2,475,250.00

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

КОД	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
	ДАНС				
C01	2017 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	-	-	-	-
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
C04	Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн	-	-	-	-
C05	Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	-	-	-
C08	2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,495,096,307.08	876,540,400.32	860,248,502.87	3,231,885,210.27
D01	2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,495,096,307.08	876,540,400.32	860,248,502.87	3,231,885,210.27
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	187,977,187.11	187,977,187.11
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,495,096,307.08	876,540,400.32	1,048,225,689.98	3,419,862,397.38
D04	Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн	-	129,836,258.65	-	129,836,258.65
D05	Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	435,360,000.00	-	(49,987,123.83)	385,372,876.17
D09	2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,930,456,307.08	1,006,376,658.98	998,238,566.15	3,935,071,532.20

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /үндсэн/

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	ДҮН	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00	(0.00)	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,040,238,400.00	967,595,759.05	72,642,640.95	93.02
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	1,040,238,400.00	967,595,759.05	72,642,640.95	93.02
210	Бараа, үйлчилгээний зардал	977,112,100.00	904,528,605.05	72,583,494.95	92.57
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	580,041,000.00	539,719,381.00	40,321,619.00	93.05
210101	Үндсэн цалин	463,727,000.00	373,666,762.00	90,060,238.00	80.58
210102	Нэмэгдэл	72,952,000.00	123,775,019.00	(50,823,019.00)	169.67
210103	Унаа, болон бусад нөхөн олговор	43,362,000.00	42,277,600.00	1,084,400.00	97.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	69,604,900.00	64,475,611.00	5,129,289.00	92.63
210201	Тэтгэврийн даатгал	46,403,300.00	64,475,611.00	(18,072,311.00)	138.95
210202	Тэтгэмжийн даатгал	5,800,400.00	-	5,800,400.00	-
210203	ҮОМШӨ ний даатгал	4,640,300.00	-	4,640,300.00	-
210204	Ажилгүйдлийн даатгал	1,160,100.00	-	1,160,100.00	-
210205	Эрүүл мэндийн даатгал	11,600,800.00	-	11,600,800.00	-
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	165,993,800.00	140,537,567.00	25,456,233.00	84.66
210301	Гэрэл цахилгаан	10,972,400.00	12,352,060.00	(1,379,660.00)	112.57
210302	Түлш, халаалт	133,753,200.00	112,091,331.00	21,661,869.00	83.80
210303	Цэвэр, бохир ус	21,268,200.00	16,094,176.00	5,174,024.00	75.67
2104	Хангамж, бараа материалын зардал	14,348,600.00	14,347,691.20	908.80	99.99
210401	Бичиг хэрэг	3,366,000.00	3,154,445.00	211,555.00	93.71
210402	Тээвэр (шатахуун)	4,207,500.00	4,203,694.00	3,806.00	99.91
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	4,544,100.00	4,073,552.20	470,547.80	89.64
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	850,000.00	670,000.00	180,000.00	78.82
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	1,381,000.00	2,246,000.00	(865,000.00)	162.64
2105	Нормативт зардал	37,452,200.00	36,294,525.85	1,157,674.15	96.91
210501	Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	386,800.00	304,650.00	82,150.00	78.76
210502	Хоол, хүнс	33,798,400.00	32,644,255.85	1,154,144.15	96.59
210503	Нормын хувцас зөөлөн эдлэл	3,267,000.00	3,345,620.00	(78,620.00)	102.41
2106	Эд хогшил худалдан авах	23,910,000.00	23,905,820.00	4,180.00	99.98
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,534,500.00	1,717,900.00	(183,400.00)	111.95
210604	Урсгал засвар	22,375,500.00	22,187,920.00	187,580.00	99.16
2107	Томилот, зочны зардал	4,417,900.00	3,988,500.00	429,400.00	90.28
210702	Дотоод албан томилот	4,417,900.00	3,988,500.00	429,400.00	90.28
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	4,464,000.00	4,383,551.00	80,449.00	98.20
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	1,500,000.00	1,440,000.00	60,000.00	96.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,700,000.00	2,694,683.00	5,317.00	99.80
210804	Тээврийн хэрэгслийн татвар	164,000.00	160,868.00	3,132.00	98.09
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	100,000.00	88,000.00	12,000.00	88.00
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	76,879,700.00	76,875,958.00	3,742.00	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	76,879,700.00	76,875,958.00	3,742.00	100.00
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	63,126,300.00	63,067,154.00	59,146.00	99.91
2132	Бусад урсгал шилжүүлэг	63,126,300.00	63,067,154.00	59,146.00	99.91
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	22,860,900.00	22,860,768.00	132.00	100.00
213208	Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж	40,265,400.00	40,206,386.00	59,014.00	99.85
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,040,238,400.00	967,595,759.05	72,642,640.95	93.02
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,031,738,400.00	962,151,681.05	69,586,718.95	93.26
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,031,738,400.00	962,151,681.05	69,586,718.95	93.26
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	8,500,000.00	5,444,078.00	3,055,922.00	64.05
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,500,000.00	5,360,000.00	3,140,000.00	63.06

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	84,078.00	(84,078.00)	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00	(0.00)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО				
620001	Удирдах ажилтан				
620002	Гүйцэтгэх ажилтан				
620003	Үйлчлэх ажилтан				
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/				
64	ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО				

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /нэмэлт/

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨ Ө	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	3,484,750.00	(3,484,750.00)	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	7,609,500.00	(7,609,500.00)	-
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	-	7,609,500.00	(7,609,500.00)	-
210	Бараа, үйлчилгээний зардал	-	6,600,000.00	(6,600,000.00)	-
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	-	6,600,000.00	(6,600,000.00)	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	6,600,000.00	(6,600,000.00)	-
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	1,009,500.00	(1,009,500.00)	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	1,009,500.00	(1,009,500.00)	-
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	-	1,009,500.00	(1,009,500.00)	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	6,600,000.00	(6,600,000.00)	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	6,600,000.00	(6,600,000.00)	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажилагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	6,600,000.00	(6,600,000.00)	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	3,484,750.00	(3,484,750.00)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	2,475,250.00	(2,475,250.00)	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО				
620001	Удирдах ажилтан				
620002	Гүйцэтгэх ажилтан				
620003	Үйлчлэх ажилтан				
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/				
64	ЭМЧЛҮҮЛЭГЭСЭДИЙН ТОО	-	-	-	-